



“ЧИНГИС ХААН” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
(ТӨВ АЙМАГ, СЭРГЭЛЭН СУМ)

Төв аймаг
2025 он

АГУУЛГА

ОРШИЛ IV

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1-1
1.1 БАЙРШИЛ	1-1
1.2 ХҮЧИН ЧАДАЛ	1-1
1.3 БАРИЛГА БАЙГУУЛАМЖ	1-1
1.4 ДЭД БҮТЭЦ	1-3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	2-1
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	3-1
3.1 АГААРЫН ЧАНАР	3-1
3.2 ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС	3-1
3.3 ХӨРСӨН БҮРХЭВЧ	3-2
3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ	3-2
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	4-1
4.1 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ	4-1
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	5-1
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	6-1
БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	7-1
БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	8-1
БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	9-1
БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	10-1
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	11-1
ДҮГНЭЛТ	

Зургийн жагсаалт

Зураг 1-1. Нисэх буудлын байршил	1-1
Зураг 1-2. НУБИЭ ХХК-ийн хариуцдаг барилга байгууламжууд	1-2
Зураг 1-3. Цахилгааны барилга	1-3
Зураг 1-4. Дулааны станцын байршил	1-4
Зураг 1-5. Дулааны станц	1-5
Зураг 1-6. Дулааны станцын нүүрс хадгалах талбай	1-5
Зураг 1-7. Гүний 3 худаг	1-6
Зураг 1-8. Ус цэвэршүүлэх байгууламж	1-6

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

Зураг 1-9. Усны химийн дотоод хяналтын лаборатори	1-7
Зураг 1-10. Бохир ус цэвэрлэх байгууламж.....	1-7
Зураг 1-11. Бохир ус цэвэрлэх байгууламжийн лаборатори.....	1-8
Зураг 1-12. Бохир ус цэвэрлэх байгууламжийн гаралтын цэг.....	1-9
Зураг 1-13. Химийн бодисуудын агуулахын байршил	1-9
Зураг 1-14. Химийн бодис хадгалах шүүгээ	1-10
Зураг 1-15. Агуулахад асгаралтын иж бүрдэл болон MSDS хайрцаг байрлуулсан байдал	1-10
Зураг 1-16. Химийн бодисын үлдэгдэл цуглуулах сав.....	1-10
Зураг 1-17. Бохир ус цэвэрлэх байгууламжийн химийн бодисын агуулах.....	1-11
Хүснэгтийн жагсаалт	
Хүснэгт 1-1. Химийн бодисын агуулахын байршил	1-9
Хүснэгт 4-1. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй ..	4-1
Хүснэгт 5-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	5-1
Хүснэгт 6-1. Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	6-1
Хүснэгт 7-1. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	7-1
Хүснэгт 8-1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	8-1
Хүснэгт 9-1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	9-1
Хүснэгт 10-1. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	10-1
Хүснэгт 11-1. Тайлагнах хуваарь	11-1

ОРШИЛ


Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОУАӨЯ-ны 2024.10.09-ний өдрийн 12/4719 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2025 онд Баялаг Эко ХХК-ийн боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгын дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон бөгөөд энэхүү БОМТ нь 2025 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлангийн эхний жилийн БОМТ юм.

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 БАЙРШИЛ

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал нь Төв аймгийн Сэргэлэн сумын 4-р (Эрдэнэ-Уул) багийн нутаг дэвсгэрт 1,010.67 га талбайд байрлана.



Зураг 1-1. Нисэх буудлын байршил

1.2 ХҮЧИН ЧАДАЛ

Чингис хаан олон улсын нисэх буудал нь жилд 1,651,000 (олон улсын 1,380,000, орон нутгийн 271,000) зорчигч хүлээн авах хүчин чадалтайгаар төлөвлөгдсөн. Одоогийн байдлаар нисэх буудал нь жилд 3,000,000 зорчигч хүлээн авах хүчин чадалтай бөгөөд гадаадын 14, дотоодын 5 агаарын тээвэрлэгч компаниуд тогтмол нислэг үйлдэж байна.


1.3 БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

НУБИЭ ХХК нь нисэх буудлын дараах барилга байгууламжуудыг хариуцна.

- Аэродром (хөөрч буух зурвас, явгалах зам, перрон)
- Зорчигч терминалын барилга
- Захиргааны барилга
- Агаарын хөлгийн газрын үйлчилгээний барилга
- Гал унтраах авран хамгаалах албаны барилга
- Карго терминалын барилга
- Дулааны станц
- Ус цэвэршүүлэх байгууламж
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Цахилгааны үндсэн өртөөний барилга

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

- Төлбөр төлөх цэгүүд, аюулгүйн хамгаалалтын постууд
- Дулаан гарааш
- Цэвэр усны худгууд
- Нийтийн эзэмшлийн автомашины зогсоол зэргийг хариуцдаг.



Зураг 1-2. НУБИЭ ХХК-ийн хариуцдаг барилга байгууламжууд

Хөөрч буух зурвас. Хөөрч буух зурвас нь хоёр чиглэлд ашиглагддаг бөгөөд 11 болон 29 гэсэн дугаартай 3600x45 м зурвастай.

Зорчигч терминалын барилга. Барилгажилтын нийт талбай 53,726 м² ба үүний 37,000 м² нь үйлчилгээний зориулалттай ба зорчигч терминалын барилгад олон улсын нислэг бүртгэлийн 30, орон нутгийн 2, хөдөлгөөнт 2 бүртгэлийн цэгтэй байна.

Барилгын фасад нь өндөр чанарын давхар шилэн хийцтэй тул гадна агаарын хэм дотор орон зайн агаарын хэмд нөлөөлөхгүй байхаар хийгдсэн. Шилэн дээвэртэй тул нэг ба хоёрдугаар давхрын танхимуудыг байгалийн гэрэлтүүлгээр гэрэлтүүлдэг.

Зорчигч терминалын барилга нь зорчигчдыг угтах, чиглүүлэх, мэдээллийн үйлчилгээ, тээш хадгалах үйлчилгээ, олсон гэсэн эд зүйлсийг хадгалах, олгох үйлчилгээ болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ зэргийг үзүүлдэг байна.

Агаарын хөлгийн газрын үйлчилгээний барилга. Агаарын хөлгийн газрын үйлчилгээний барилгын нийт талбай 4431.1м², гараашны хэсэг 2669.5м², машин угаалга 141м², засварын хэсэг 484.33 м² байна.

Аврах гал унтраах алба. НУБИЭ ХХК нь ИКАО-ын шаардлагыг хангасан Аврах, гал унтраах хэлтэстэй бөгөөд нисэх буудал дээр болон 8 км-ийн радиуст болсон агаарын хөлгийн гал, осол, зөрчлийн үед хүний амь нас, эд хөрөнгийг авран хамгаалах үүрэгтэй ажилладаг.

ИКАО-гийн удирдамжид зааснаар гал унтраах багийнхан нь дохиолол хүлээн авснаас хойш харагдах орчны хүрээнд орших, замын нөхцөл сайтай зурвасын дурын хэсэгт 2

минутын дотор, нисэх хөлгүүдийн хөдөлгөөний талбай дах бусад дурын цэгт 3 минутаас бага хугацаанд амжиж хүрэх ёстой. Иймээс ИКАО- гийн удирдамжийн энэхүү шаардлагад нийцүүлэхийн тулд гал унтраах анги нь зурвасын дунд хэсэгт ойрхон, нисэх зурваст хамгийн богино хугацаанд хүрэх боломж бүхий газарт байрлаж байна.

Карго терминалын барилга. Чингис хаан ОУНБ -ын Карго терминалын барилга нь агаарын тээврээр тээвэрлэгдэх экспортын болон импортын карго, шууданг газрын тээвэртэй холбох цогц үйлчилгээг хүргэдэг байна. Нисэх буудал дахь гаалийн газар, түүний хорио цээрийн алба, агаарын тээвэрлэгч авиа компаниуд, гаалийн болон тээвэр зуучлагч компаниудын үйл ажиллагааг нягт уялдуулж иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд түргэн шуурхай үйлчлэхийг зорьж ажилладаг.

Олон улсын болон орон нутгийн нислэгээр тээвэрлэгдэж ирсэн, тээвэрлэгдэж явах бүх төрлийн ачаа, шууданг нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангаж ачиж буулгах, тээвэрлэлтэд бэлтгэх, хүлээн авах болон хадгалах цогц үйлчилгээг Олон улсын Иргэний нисэхийн байгууллага (ИКАО), Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооноос (IATA) гаргасан стандарт, заавар, дүрмийн дагуу чанарын өндөр түвшинд үйлчилгээ үзүүлж байна.

Карго терминалын барилга нь жилд 11,900 тн ачаа, шуудан нэвтрүүлэх хүчин чадалтай бөгөөд аюултай ачааны агуулах экспорт импорт тус бүрт 28 м², үнэт ачааны агуулах экспорт импорт тус бүрт мөн 28 м² талбайтай. Хөргөлттэй агуулах 12 м², хөлдөөгчтэй агуулах 44 м², 40 тн чингэлэг хөргүүртэй (+2+8 °C, -15-25 °C) агуулах 28.1 м², 750-2,500 кг хүртэл хүчин чадалтай 3 сэрээт өргөгчтэй байна.

1.4 ДЭД БҮТЭЦ

Цахилгаан хангамж хэрэглээ. Нисэх буудал нь 110/10кВ-ын Хөшигт дэд станцаас цахилгаан эрчим хүчээр хангагддаг. 110/35/10 кВт-ын Налайх дэд станцаас 119 дүгээр агаарын шугамаар, 220/110/35 кВт-ын Сонгино дэд станцаас 121, 122-р агаарын шугамаар, 110/10 кВт-ын Бөхөг дэд станцаас 139, 140 агаарын шугам гэсэн 3 талын тэжээлтэй. Үндсэн, салбар дэд өртөөнүүд эрчим хүчний системээс хүчдэлгүй болсон тохиолдолд 50-2,250 кВт чадал бүхий дизель генераторуудаар барилгуудыг эрчим хүчээр хангана.



Зураг 1-3. Цахилгааны барилга

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он


Эрчим хүчний системээс хүчдэлгүй болсон тохиолдолд тус дэд өртөө нь 400 кВА чадал бүхий дизель генератороор барилгыг эрчим хүчээр хангана.

Цахилгааны үндсэн дэд өртөөнөөс 10 кВ-ын сүлжээгээр (PTB, CT, HP, STP, HG, VOR/DME, LLZ, GP, FSS, Sky catering, хил гааль, хурдны зам, Монгол шуудан, ангар, карго барилга байгууламжуудыг, 0.4 кВ-ын сүлжээгээр (AMB, GSE, WTP) тэжээх бөгөөд байгууламж бүрт өөрийн бие даасан 10/0.4 кВ-ын болон 0.4 кВ-ын дэд өртөөтэй.

Хүчдэл тасрах, эрчим хүчний системд гэмтэл саатал гарсан үед 50-2,250 кВА чадал бүхий дизель генераторуудаар тухайн барилгын ослын талын хэрэглэгчдийг тэжээнэ. Байгууламжуудын дэд өртөө нь дэлхийд тэргүүлэх эрчим хүчний тоног төхөөрөмж үйлдвэрлэгч болох ABB фирмийн хуурай трансформатор, ячейк, хуваарилах самбар, щитээр тоноглогдсон.

Нисэх буудлын барилга байгууламжуудын кабелийн шугам сүлжээнд 50-240 мм хөндлөн огтлол бүхий 80000 метр кабель шугамыг ашиглан 1.8 км инженерийн (тунель) шугам сүлжээгээр цахилгаан эрчим хүчийг түгээж байна.

Дулаан хангамж хэрэглээ. Нисэх буудлын дулаан хангамжийг зорчигч терминалын барилгаас зүүн урд зүгт 4 км зайд байрлах дулааны станцаас хангана. Дулааны станц нь халаалтын улиралд ажиллана. Тус дулааны станц нь SHF14.1.25/150/70-AI загварын тус бүрдээ 14 Мвт-ын хүчин чадалтай буцламгай үет шаталттай ус халаагуурын 3 зуухтай бөгөөд халаалтын улиралд 2 зуух, нөөцөд 1 зуухыг ээлжилж ажиллуулдаг. Дулааны станц нь нисэх буудлын бүхий л барилга байгууламжуудыг дулааны хангадаг.



Зураг 1-4. Дулааны станцын байршил

Дулааны станц нь хашаандаа нүүрс буулгах талбай болон бараа материалын агуулахтай.

**“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он**



Зураг 1-5. Дулааны станц

Дулааны станцын яндангийн өндөр 45 м бөгөөд Багануурын хүрэн нүүрс хэрэглэдэг бөгөөд гэрээт байгууллагаас худалдан авдаг.



Зураг 1-6. Дулааны станцын нүүрс хадгалах талбай

Нүүрсийг салхинд хийсэхээс сэргийлсэн 2 м өндөртэй торон хашаа нь бетон суурьтайгаа нийлээд 3 м өндөр байна.

Зуухны шаталт нь буцламгай үет шатлалттай, нам температурт буцалгадаг байна. Буцламгай үет шатлалттай зуухны технологийн процессоос шалтгаалж үнсээ зуухнаас – шаарга болон уутат фильтрээр гэсэн 2 аргаар зайлуулдаг.

Дулааны станц нь яндан дахь утааны хийг 60,000 м³ цагийн хүчин чадалтай уутат фильтрээр шүүдэг бөгөөд тус фильтр нь техникийн үзүүлэлтээр 99.98% шүүдэг байна.

Усан хангамж. Нисэх буудлын усны эх үүсвэрийг дулааны станцын барилгаас зүүн урд зүгт 4 км зайд байрлах өөрийн эзэмшлийн 3 ш гүний худгаас хангана.

**“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он**



Зураг 1-7. Гүний 3 худаг

Нисэх буудалд байрлах ундны усны эх үүсвэрт 100 м, ус цэвэршүүлэх байгууламж 50 м энгийн хамгаалалтын бүстэй.

Ус цэвэршүүлэх байгууламж. Ус цэвэршүүлэх байгууламж нь карго терминалын барилгын хойд талд байрлах бөгөөд замын хойд талд нь цахилгааны үндсэн дэд өртөө байрлана.



Зураг 1-8. Ус цэвэршүүлэх байгууламж

Эх үүсвэрийн 3 гүний худгаас усыг олборлон ус цэвэршүүлэх байгууламжид байрлах түүхий ус хүлээн авах санд усыг хүлээн авч $800 \text{ м}^3/\text{хон}$ хүчин чадалтай механик шүүлтүүрээр шүүж натри гипохлоридын уусмалаар халдваргүйжүүлэн нийт $1,110 \text{ м}^3$ усыг нөөцлөн, MNS 0900:2018. Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартын шаардлагад нийцсэн усыг цэвэршүүлж хадгалах 400 м^3 багтаамжтай 2 ш санд нөөцөлж, 4 өргөлтийн насосоор дамжуулан хэрэглэгчдийг ундны усаар тасралтгүй ханган ажилладаг байна.

Ус цэвэршүүлэх байгууламжийн 1 давхарт механик шүүлтүүр болон тоног төхөөрөмжүүд, зоорины давхарт ус нөөцлөх сангууд, түгээлтийн насосууд байрладаг. Цэвэр ус дамжуулах шугамын урт нь 4,451 м, голч нь 125 мм, хуванцар хоолойтой байна.

Ус цэвэршүүлэх байгууламж дотор НУБИЭ ХХК-ийн ундны усны химийн дотоод хяналтын лаборатори байрлана.



Зураг 1-9. Усны химийн дотоод хяналтын лаборатори

Тус лаборатори нь Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2024 оны 02 сарын 26-ны өдрийн А/46 дугаар тушаалаар итгэмжлэгдсэн бөгөөд ундны усанд рН, цахилгаан дамжуулах чанар, ерөнхий хатуулаг, кальци, магни холимог шүлтлэг, нийт шүлтлэг, гидрокарбонат, хлорид, сульфат, нийт төмөр, аммони, нитрат, нитрит, хуурай үлдэгдэл, фосфат, фтор, үлдэгдэл хлор, натри + кали, ууссан хүчилтөрөгч зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлдог байна.

Бохир ус цэвэрлэх байгууламж. Нисэх буудлын хэмжээнд гарч байгаа ахуйн бохир усыг цэвэрлэх цэвэрлэх байгууламжтай бөгөөд бохир ус цэвэрлэх байгууламж нь зорчигч терминалын барилгаас баруун зүгт 800 м зайд аэродромын барилгын хойд талд байрлана.



Зураг 1-10. Бохир ус цэвэрлэх байгууламж

үйлдвэрлэсэн бөгөөд бүрэн автомат удирдлагын системтэй, 2 ш бохир ус өргөх станцтай. Нисэх буудлын барилга байгууламжуудаас гарсан ахуйн хэрэглээний бохир усыг цуглуулах шугам сүлжээний 3.7 км урт, 66 ш хяналтын худагтай, шугам хоолойн голч 50-300 мм, цэвэршүүлсэн бохир усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэх шугам сүлжээний урт 2.2 км, хяналтын (траншейн) худаг 7 ш, шугам хоолойн голч 200 мм байна.

**“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он**

Зөөврийн бохир усыг хүлээн авч механик болон биологийн цэвэрлэгээг хийж MNS 4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага стандартад нийцүүлэн байгальд нийлүүлдэг байна.

Бохир ус цэвэрлэх байгууламж нь үечилсэн зарчмаар ажиллах бөгөөд цэвэрлэх байгууламж нь хоногт 800 м³ бохир ус хүлээн авах хүчин чадалтай ба цагийн дундаж зарцуулалт 33.3 м³, цагийн хамгийн их зарцуулалт 133 м³ байна. Тус цэвэрлэх байгууламж нь бохир усыг 96-98 % хүртэл цэвэрлэх хүчин чадалтай.

Бохир ус цэвэрлэх байгууламжид нисэх буудлын бусад барилга байгууламжуудаас ирж буй бохир усыг хянадаг суурин төхөөрөмжтэй бөгөөд 30 секундйн давтамжтай ирж буй усны бохирдлыг хэмжиж дата мэдээллийг цуглуулдаг байна.

Газрын үйлчилгээний барилгад агаарын хөлгийн бохир соруулдаг 2 ш машин байдаг бөгөөд тухайн машинаар агаарын хөлгийн бохирыг соруулан цэвэрлэх байгууламжинд нийлүүлдэг байна.

Бохир ус цэвэрлэх байгууламжийн лабораторид 5 нэр төрлийн химийн бодисуудыг ашиглана.



Зураг 1-11. Бохир ус цэвэрлэх байгууламжийн лаборатори

Бохир ус цэвэрлэх байгууламжид механик болон биологийн цэвэрлэгээ хийсний дараа гаралтын усыг MNS 4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага стандартад нийцүүлэн байгальд хаядаг байна.



**“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он**

Зураг 1-12. Бохир ус цэвэрлэх байгууламжийн гаралтын цэг

НУБИЭ ХХК нь Говийн марз хайрхан ХХК-тай нисэх буудлын төвийн шугамд холбогдоогүй барилга байгууламжийн бохир усыг зөөвөрлөх гэрээ байгуулсан ба цэвэрлэх байгууламжийн 1-р худаг руу хийдэг.


Химийн бодисын агуулах, хэрэглээ

НУБИЭ ХХК нь нисэх буудалд химийн бодисын нийт 4 агуулахтай бөгөөд нийт 110 нэр төрлийн химийн бодисын ашиглана.

Хүснэгт 1-1. Химийн бодисын агуулахын байршил

№	Агуулахын байршил	Зориулалт
1.	Ус цэвэршүүлэх байгууламж дотор	Химийн бодисын агуулах
2.	Бохир ус цэвэрлэх байгууламж дотор	Химийн бодисын агуулах
3.	Аэродромын барилга 1 давхарт	Карбомид болон давсны агуулах
4.	Газрын үйлчилгээний барилгын гадна талд	Мөстөлтийн эсрэг шингэний агуулах

Агуулахуудын байршлыг доорх зурагт харуулав.



Зураг 1-13. Химийн бодисуудын агуулахын байршил

- Усны дотоод хяналтын лабораторийн химийн бодисын агуулах.** Ус цэвэршүүлэх байгууламж дотор байрлах усны химийн дотоод хяналтын лабораторид ашиглах химийн бодисуудыг тус агуулахад хадгалдаг.

**“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он**



Зураг 1-14. Химийн бодис хадгалах шүүгээ

Агуулахад химийн бодисын ХАЛМ, аюулгүй ажиллагааны самбар, анхны тусламжийн самбар, асгаралтын иж бүрдэл зэргийг байрлуулсан.



Зураг 1-15. Агуулахад асгаралтын иж бүрдэл болон MSDS хайрцаг байрлуулсан байдал

Химийн бодисын үлдэгдлийг тусгай саванд хадгалж, Элемент ХХК-д “Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах, ландфиллдэх” гэрээний дагуу тээвэрлүүлдэг.



Зураг 1-16. Химийн бодисын үлдэгдэл цуглуулах сав

Лабораторид ашиглах химийн бодисуудын хэмжээ бага учраас химийн бодисын үлдэгдэл бага байна. Тус лабораторид 97 нэр төрлийн химийн бодисыг хадгална.

- 2. Бохир ус цэвэршүүлэх байгууламжийн химийн бодисын агуулах.** Бохир ус цэвэрлэх байгууламж дотор химийн бодисын агуулахтай. Тус агуулахад 5 нэр төрлийн химийн бодисыг хадгална.



Зураг 1-17. Бохир ус цэвэрлэх байгууламжийн химийн бодисын агуулах

Агуулахад химийн бодисын ХАЛМ, аюулгүй ажиллагааны самбар, анхны тусламжийн самбар, асгаралтын иж бүрдэл зэргийг байрлуулсан.

3. **Карбомид болон давсны агуулах. Аэродромын барилгын 1 давхарт байрлана.** Аэродромын газарт өвлийн улиралд зурвасын цасыг хайлуулах зорилгоор карбомид (кальцийн хлорид) болон техникийн давсыг хэрэглэдэг. 2024 оны байдлаар агуулахад карбомидын үлдэгдэл 45,435 кг байна. Давсны агуулахад гербицидийг хамт хадгална. Зурвасын хог ургамлыг устгах зориулалтаар гербицидийг хэрэглэнэ.
4. **Мөстөлтийн эсрэг шингэн хадгалах агуулах.** Газрын үйлчилгээний барилгын баруун талд мөстөлтийн эсрэг шингэний агуулах байрлана.

Өвлийн улиралд агаарын хөлгийг мөстөлтөөс хамгаалах зорилгоор хэрэглэнэ. НУБИЭ ХХК Мөстөлтийн эсрэг шингэнийг Цэпү констракшн ХХК-аас гэрээний дагуу Type IV Anti-icing Fluid (Cryotech Polar Guard Advance) төрлийн мөстөлтийн эсрэг шингэнийг худалдан авдаг.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл. Төв аймаг нь Хангай, Хэнтийн уулархаг, Дорнод Монголын талархаг мужид багтана. Нутгийн хойд хэсгийн уулын өргөн хөндийнүүд нь газар тариаланд тохиромжтой хүрэн бор хөрстэй, өмнөд хэсэг нь гүвээ толгод бүхий тал хээр газар юм.

Чингис хаан олон улсын нисэх буудлын ашиглалтын нийт талбайн өндөржилт 1350-1390 метрийн үнэмлэхүй өндөрт, 1-20° налуужилттай талбайд байрлаж байна. Үүнээс нисэх буух зурвас талбай нь 0-3° хэмийн налуужилттай, нийт талбайд 1-7° хэмийн налуужилт давамгайлсан байна.

Нисэх буудал нь Монгол орны байгалийн бүс бүслүүрээр хээрийн бүсэд байрлана.

Хөрсөн бүрхэвч. Төслийн талбай нь хөрсний газарзүйн мужлалаар (Монгол орны үндэсний атлас) хөрс-био уур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн мужийн Хэнтийн төвийн тойрогт багтана.

Төв аймгийн нутаг дэвсгэрт хамаарах Хөшигийн хөндийд байрлах “Чингис хаан” Олон улсын нисэх буудал нь хөрс-газарзүйн мужлалтаар Хэнтийн захын 39-р тойрогт багтана.

Тус ашиглалтын нийт талбайн 70%-ийг барилга байшин, хатуу хучилттай зам, талбай, усны цементэн урт далан эзлэх ба бусад 30%-д нь ногоон байгууламж бүхий зүлэг, ургамалтай талбай эзэлнэ. Нисэх буудлын талбайн захаар тавигдсан Усны хамгаалалтын сувгийн далангийн ёроол болон 2 талын хажууг цементэн хавтангаар доторлож хөрсний эвдрэлээс хамгаалагдсан байна.

Ургамлан нөмрөг. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Монгол Дагуурын уулын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Тус нутагт ургамалжлын өндөр уул таг цармын, уулын тайга, уулын хээр буюу уулын ойт хээрийн гэсэн үндсэн 3 бүслүүрийн ургамалжил тохиолдох онцлогтой.

Ургамалжлын хувьд Монгол Дагуурын ойт хээрийн болон хээрийн бүлгэмдэлтэй бөгөөд нам уулс, өндөрлөг толгодын ар хажуугийн дээд хэсгээр нугажуу хээрийн улалж-алаг өвс-үетэнт бүлгэмдэл бүхий сөөгөн ширэнгэ тохиолдоно. Хэнтийн тайгын өмнөд зах боловч тайгын ойгүй, алаг өвст, улалжийн сөөгт, шинэсэн, хус- шинэсэн ой, шинэс – хусан тайгархаг ой тохиолдоно. Ойн бүслүүрт голуудын эх, нарийн аманд торлог элбэг тохиолддог. Монгол оронд хязгаардмал тархалттай байдаг нугын хээрийн сөөгөн боролзгонот, алаг өвст, зогдор улалжит, зүр өвст, байгалийн хялганат зэрэг нугын хээрийн бүх хэвшлүүд байдаг.

Нисэх буудлын хашааг тэгшилж засаж зам, барилга барьж үерийн шуудуу татсан. Тэгшилсэн талбайн тусгай зориулалтаас бусад хэсгийг нөхөн сэргээсэн бөгөөд зарим хэсэг нь байгалийн унаган бүлгэмдэлтэй.

Нисэх буудлын талбай нь тэгш хөндийд байрлах хашаалж хамгаалсан Шивээт хялганат бүлгэмдэлтэй 42 зүйл ургамал тэмдэглэсэн. Бичиглэл хийсэн талбайн хашаалсан талбайн захаар ургах бөгөөд тусгагийн бүрхэц 80%, хагд 5%, 10 зүйлийн ургамал (бичиглэл-1) бүртгэгдсэн, ургац 12,1 ц/га байсан. 20-60 см хүртэл өндөртэй байсан. Үетнээс шивээт хялгана, алаг өвснөөс агь, марал навчит гичгэнэ, шар өрөмтүүл зэрэг ургамлууд ургана. Бэлчээрийн талхагдал байхгүй хашаалж хамгаалсан.

Агаарын чанар. Чингис хаан ОУНБ-ийн төслийн 2014 - 2016 онуудын бүтээн байгуулалтын үе болон 2020-2024 онуудын үйл ажиллагааны үе шатанд агаарын

**“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он**

чанарын хяналт шинжилгээний ажлыг 6 -7 цэгт жил бүр хийлгэж байсан. Нисэх буудлын бүтээн байгуулалтын үе шатанд орчны агаарын чанарт нөлөөлөх хэмжээний бохирдол үүсээгүй ба мониторингийн ихэнх цэгүүд дээр бохирдуулагчдын агууламж болон шуугианы төвшин холбогдох стандарт шаардлагуудыг хангаж байсан.

Мөн үйл ажиллагааны үе шатанд хийсэн агаарын чанарын хяналт шинжилгээний ихэнх үр дүнгүүд агаарын чанарын стандартад заасан хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлтгүй гарсан байна. Харин 2023 оны БОМТ-ний биелэлтийн тайланд дурдсанаар ДС-ын хаягдал утааны хэмжилтийн дүнгээр нүүрсхүчлийн дутуу исэл (СО) зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү гарсан тул гэрээт нийлүүлэгчийг сольсон бөгөөд 2025 оны 2 сард Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газраар холбогдох хэмжилтийг хийлгэхэд стандарт үзүүлэлтийн хэмжээнд байсан.

Биологийн олон янз байдал.

Хөхтөн амьтан. Нисэх буудал орчимд гүйцэтгэсэн судалгааны үр дүн, өмнө хийгдсэн БОНБНУ-ий тайлан, Батсайхан нар, 2014 бүтээлтэй харьцуулан үзэхэд 6 баг 13 овгийн 22 зүйл хөхтөн амьтан тэмдэглэгджээ. Үүнээс Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан дансны шалгуураар олон улсын болон бүс нутгийн ховордлын зэрэглэлтэй Монгол тарвага, хярс, шар үнэг, саарал чоно зэрэг амьтад байна. Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай Конвенцийн хавсралтад шар үнэг, саарал чоно, Зэрлэг амьтны нүүдлийн зүйлийг хамгаалах тухай Конвенцийн хавсралтад буурал сармаахай тус тус тэмдэглэгдсэн байна. Нисэх буудлын хамгаалалтын талбай орчим болон ойролцоох нутгаар үлийн цагаан оготно, хярс, дагуур огдой, бор туулай түгээмэл тохиолдоно.

Шувуу. Нисэх буудлын орчимд бүртгэгдсэн шувуудын агаарын хөлөгт аюул учруулах эрсдэлийг С. Paton (2009) аргаар үнэлсэн ба арга зүйн дагуу шувуудын биеийн жин, нисэх тоо толгой болон зан төрхийн байдалд тулгуурлан агаарын хөлөгт учруулах аюулыг бүртгэгдсэн шувууны зүйл тус бүрт тодорхойлов. Улмаар шувуудын агаарын хөлөгтэй мөргөлдөх магадлал буюу тухайн нисэх буудлын орчимд тохиолдох давтамжийг тодорхойлон, Магадлал-үр дагаврын матриксийг ашиглан эрсдэлийн үнэлгээг хийв. Нийт бүртгэгдсэн 62 зүйл шувуудын 3.22% нь “Маш их аюултай”, 17.4 % нь “Их аюултай”, 25.8 % нь “Дунд аюултай”, 9.67 % нь “Бага аюултай” , 43.5 % нь “Ач холбогдолгүй” үнэлгээтэй байна.

Нисэх буудлын аэродромын талбайгаас 15 км радиус дахь хад чулуурхаг болон нүцгэн уулс, хадан цохио гуу жалга, суурин газар, харгана, бутлаг ургамал бүхий хөндий, хээр, уулын хээр, ус намгархаг жижиг нуур, голын хөндий зэрэг ялгаатай амьдрах орчинд 125 зүйл шувуу тохиолдоно. Экологийн статусийн хувьд нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг (84 зүйл буюу 85.7%), суурин 17 зүйл, нүүдлийн өндөглөдөг 16 зүйл, өвөл орж ирдэг 3 зүйл шувууд тус тус тэмдэглэгджээ. Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (ДБХХ)-ны улаан дансны шалгуураар олон улсад ховордлын зэрэглэлтэй 13 зүйл (нөмрөг тас, цэн тогоруу, тарважи бүргэд, улаан хүзүүт шумбуур, хадуур элсэг, шар түрүүт элсэг, бор бүргэд, наран бөднө, идлэг шонхор, морин цууцал, гээгт нугас, хонин тоодог, умардын хавтгаалж); бүс нутгийн буюу Монгол орны хэмжээнд ховордлын зэрэглэлтэй 6 зүйл (цэн тогоруу, бор бүргэд, идлэг шонхор, хархираа тогоруу, гээгт нугас, хонин тоодог); Монгол улсын Улаан ном (2016)-нд 5 зүйл (цэн тогоруу, бор бүргэд, хархираа тогоруу, гээгт нугас, хонин тоодог) тус тус бүртгэгдсэн.

Ургамал. 2024 оны 06 дугаар сард хийгдсэн хээрийн судалгааны үед нисэх буудлын онцгой бүсэд 5 цэгт 10 км-ийн тойрогт нийт 14 цэгт бүрэн бичиглэл хийж зүйлийн бүрэлдэхүүн, ургамлан бүрхэвч, биомасс зэргийг тодорхойлсон.

Нисэх буудлын талбай болон тухайн орчмын нутаг дэвсгэр нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө хуурай хээрийн ургамалжилтай.

**“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он**

Нисэх буудлын хашааг тэгшилж засаж зам, барилга барьж үерийн шуудуу татсан. Тэгшилсэн талбайн тусгай зориулалтаас бусад хэсгийг нөхөн сэргээсэн бөгөөд зарим хэсэг нь байгалийн унаган бүлгэмдэлтэй. Согоовроор нөхөн сэргээлт хийгдсэн бөгөөд байгалийн унаган ургамал түрж ургасан. Хөөрч буух зурвасын талбайн гол хэсгийг согоовроор нөхөн сэргээсэн согооврын бүрхэц 80-96% байна. Замын хажуугаас байгалийн ургамлууд ургасан. Энд байгалийн унаган ургамлаас шивээт хялгана, имт гичгэнэ, нангиад түнгэ, багваахай, таван салаа түрэн ургаж байна.

Нисэх буудлын талбайд ургаж байгаа 78 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 20 зүйл нэг наст өвслөг ургамал (25.64%), 54 зүйл олон наст өвслөг ургамал (69.23%), 4 зүйл сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (5.13%) ургаж байна.

Нисэх буудлын талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Монгол Дагуурын уулын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Тус нутагт ургамалжлын өндөр уул таг цармын, уулын тайга, уулын хээр буюу уулын ойт хээрийн гэсэн үндсэн 3 бүслүүрийн ургамалжил тохиолдох онцлогтой.

Цармын ой хээрийн болон нугын хэв шинжид хамаарах ургамлан нөмрөгтэй бөгөөд нийт талбай нь 55.8% буюу 22.9 мянган га газрыг ой мод эзэлнэ. Үүнээс шинэс 56.8%, хуш 22.2%, гацуур 15.4%, нарс 1.4%, хус 2.6, бут сөөг 1 хувийг тус тус эзэлнэ.

ургамлын амьдралын хэлбэрээр нисэх буудлын талбайд ургаж байгаа 78 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 20 зүйл нэг наст өвслөг ургамал (25.64%), 54 зүйл олон наст өвслөг ургамал (69.23%), 4 зүйл сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (5.13%) ургаж байна.

Ургамлын аж ахуйн холбогдлын ангиллаар нисэх буудлын талбай дахь бүх зүйл ургамлаас 21 овгийн 54 төрлийн 62 зүйл бэлчээрийн (79.48%), 13 овгийн 30 төрлийн 38 зүйл эмийн ашигт ургамал (48.72%), 13 овгийн 23 төрлийн 32 зүйл хөл газрын ургамал (41.02%) бүртгэгдсэн.

Амьтан. Нисэх буудал орчимд гүйцэтгэсэн судалгааны үр дүн, өмнө хийгдсэн тайланд дурдсанаар 6 баг 13 овгийн 22 зүйл хөхтөн амьтан тэмдэглэгдсэн. Үүнээс Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан дансны шалгуураар олон улсын болон бүс нутгийн ховордлын зэрэглэлтэй Монгол тарвага, хярс, шар үнэг, саарал чоно зэрэг амьтад байна. Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсад худалдаалах тухай Конвенцийн хавсралтад шар үнэг, саарал чоно, Зэрлэг амьтны нүүдлийн зүйлийг хамгаалах тухай Конвенцийн хавсралтад буурал сармаахай тус тус тэмдэглэгдсэн байна.

Нисэх буудлын хамгаалалтын талбай орчим болон ойролцоох нутгаар үлийн цагаан оготно, хярс, дагуур огдой, бор туулай түгээмэл тохиолдоно.

Энэ нутгийн хөхтний жагсаалтад зараа, шавж идэштэн, туулай, мэрэгч, мах идэштэн, туруутан гэсэн 6 баг, 24 зүйл тохиолдож болно хэмээн бүртгэсэн. Эдгээрээс мэрэгчид болон махчдын зүйл түлхүү зонхилно. Махчин амьтдаас хярс үнэг, шар үнэг, саарал чоно, халздай дорго, өмхий хүрэн, мануул гүйдлээр болон суурин байдлаар байршин амьдарна. Цагаан зээр зэрэг том туруутан амьтад улирлын онцлог, цасан бүрхүүл, ган зуд зэрэгтэй холбоотойгоор энэ орчимд ажиглагдаж болох хэдий ч суурин байдлаар суурьшлын бүсэд байршихгүй. Харин шилжилт хөдөлгөөн хийх үедээ зэргэлдээх уулсаар дамжин өнгөрнө.

Монгол улсын амьтны аймгийн тухай хууль, ховор, амьтны жагсаалт болон улаан номд орсон зүйл одоогоор тэмдэглэгдээгүй. Энд Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн II хавсралтад мануул орсон. Монгол улсын хөхтөн амьтны Улаан дансанд “Ховордож болзошгүй” ангиллаар шар үнэг, хярс үнэг, мануул оржээ. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцын II хавсралтад цагаан зээр орсон.

**“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он**

Олон улсын байгаль хамгаалах холбооны улаан дансны ангиллаар олон улсын түвшинд хээрийн солонго, мануул гэсэн 2 зүйл махчин NT буюу Ховордож болзошгүй гэж үнэлэгдсэн бол үлдсэн зүйлүүд анхааралд өртөөгүй (LC) гэж үнэлэгдсэн. Бүс нутгийн үнэлгээгээр (2006) цагаан зээр EN буюу Устаж болзошгүй, хярс үнэг, шар үнэг, мануул гэсэн 3 зүйл NT буюу Ховордож болзошгүй гэж үнэлэгдсэн. Үлдсэн 20 зүйл нь анхааралд өртөөгүй (LC) гэж үнэлэгдээ (Clark et al., 2006) Судалгааны талбай орчимд тохиолдох мэрэгчид нь хөрсний сийрэгжилт, сэлгэлт, эрдэсжилт, нөхөн сэргэлтэд бусад мэрэгчдийн адил чухал үүрэгтэйн дээр тухайн бүс нутагт тархсан мах идэшт амьтдын хувьд улирлын чанартай идэш тэжээлийн зонхилох хэсгийг эзэлдэг онцгой ач холбогдолтой зүйл юм

Нийгэм эдийн засгийн байдал. Хүн амын тооны хувьд 2024 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсад 997,023 өрхийн 3,441,598 хүн ам амьдарч байгаа бөгөөд үүнээс төвийн бүсийн хүн амын тоо 517,621 буюу 15.04% байгаагаас Төв аймагт 28,896 өрхийн 91,939 буюу Монгол улсын нийт хүн амын 2.67% оршин сууж байна. Төв аймгийн нийт өрхийн 5,166 буюу 17.91% хот, 23,730 буюу 82.14% хөдөөгийн өрх байна.

Төв аймаг. Нийт хүн амын тоо 47,884 буюу 52.08% эрэгтэй, 44,055 буюу 47.93% эмэгтэй хүн байна.

Сэргэлэн сум. 2024 оны жилийн эцсийн байдлаар Сэргэлэн суманд 785 өрхийн 2,049 хүн буюу Төв аймгийн нийт хүн амын 2.23% амьдарч байна. Сэргэлэн сумын нийт хүн амын 1,172 буюу 57.22% эрэгтэй, 877 буюу 42.78% эмэгтэй хүн байна.

4-р баг. 2024 оны жилийн эцсийн байдлаар Сэргэлэн 4-р багт 192 өрхийн 521 хүн буюу Сэргэлэн сумын нийт хүн амын 25.43% амьдарч байна. Сэргэлэн сумын 4-р багийн нийт хүн амын 291 буюу 55.86% эрэгтэй, 230 буюу 44.15% эмэгтэй хүн байна.

Сэргэлэн сум нийт 5 багтай бөгөөд хамгийн их хүн амтай баг Хайрхан 521, Авдар 496, Баянбүрд 384, Хөшиг 323, Эрдэнэ-Уул буюу нисэх буудал байрлах баг нь 298 хүн амтай буюу хамгийн бага хүн амтай байна.

Аж үйлдвэр. Аж үйлдвэрийн салбарын дүнгээр 2024 онд 337.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь 2023 оноос 0.3 хувь буюу буюу 0.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

2024 онд нийт үйлдвэрлэлтэд дулааны эрчим хүч 3.2, боловсруулах үйлдвэрлэл 49.6, уул уурхай, олборлолт 46.8 хувийг тус тус эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарт 2024 оны 12-р сард нийт 916 хүн ажиллаж бүтээмж 367.9 сая төгрөг байгаа нь 2023 оны мөн үеэс 1.6 дахин, 2022 оны мөн үеэс 1.8 дахин өссөн байна.

Хөдөө аж ахуй. 2024 оны 10-р сарын 1-ний байдлаар төллөх насны хээлтэгчийн 61.1% 1443.7 мянган хээлтэгч мал төллөж, 1445.9 мянган төл гарсны 85.7% 1238.7 мянган төл бойжиж байгаа нь 2023 оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 29.4% буюу 424.7 мянгаар, бойжиж буй төл 39.2% буюу 485.4 мянган төлөөр, 2015-2023 оны мөн үеүдийн дунджаас төллөсөн хээлтэгч 20.7% 298.1 мянгаар, бойжиж буй төл 359% 4443 мянгаар тус бүр өссөн байна.

2024 онд Төв аймгийн дүнгээр 65371.0 га талбайд үр тариа, 12097.0 га талбайд төмс, 3236.9 га талбайд хүнсний ногоо, 39837.4 га талбайд тэжээлийн ургамал, 22875.0 га талбайд техникийн ургамал тариалсан нь 2023 оноос үр тариа 2990 га, төмс 455.6 га талбайгаар өсөж, хүнсний ногоо 112.8 га, тэжээлийн ургамал 891.3 га, техникийн ургамал 3833.0 га талбайгаар тус тус буурсан байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 АГААРЫН ЧАНАР

Онгоц хөөрч, буух үед үүсэх агаар бохирдуулагч. Онгоц хөөрөх, буух явцад нисэх буудлын аэродромын бүсэд түлш шаталтаар үүсэх азотын ислүүд (NO_x), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), нүүрстөрөгчийн давхар исэл (CO_2), хүхрийн ислүүд (SO_2), дэгдэмхий органик нэгдлүүд (VOC), тоосонцор (PM_{10} , $\text{PM}_{2.5}$) зэрэг олон төрлийн агаар бохирдуулагч бодис агаарт ялгарна. Энэхүү ялгаруулалт нь онгоцны хөдөлгүүрийн шаталтаар үүсэх бөгөөд нисэх буудлын орчмын агаарын чанарт бодит нөлөө үзүүлэх хүчин зүйл болдог.

Агаарын хөлөг хөөрч буух үед жилд 53 тн хүхэрлэг хий, 547.2 тн азотын хий, 837.6 тн нүүрстөрөгчийн дутуу исэл тус тус үүсэж нисэх буудал орчмын агаар бохирдуулагчдын агууламжийг нэмэгдүүлж болзошгүй байна.

Дулааны станцаас үүсэх агаар бохирдуулагч. Нисэх буудлын дэд бүтэц, барилга байгууламжийг дулаан, халуун усаар хангах зорилгоор ажиллаж буй дулааны станц нь Багануурын хүрэн нүүрс түлш болгон ашигладаг. Нисэх буудлын дэд бүтэц, барилга байгууламжийг халуун ус, дулаанаар хангах зорилгоор баригдсан дулааны станц нь жилд 25,641 тн Багануурын хүрэн нүүрсийг хэрэглэдэг бөгөөд дулааны станцын үйл ажиллагаанаас жилд 313.92 тн хүхэрлэг хий, 21.12 тн азотын хий, 3.59 тн нийт тоос, 2.43 тн PM_{10} тоосонцор, 0.99 тн $\text{PM}_{2.5}$ тоосонцор тус тус үүсгэж, 37,330.82 тн хүлэмжийн хий ялгаруулж нисэх буудал орчмын агаар бохирдуулагчдын агууламжийг нэмэгдүүлж болзошгүй байна.

Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулагч. Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас олон төрлийн агаар бохирдуулагч ялгардаг. Түлшний найрлагад агуулагдах бодисууд болох хүхэр болон нүүрстөрөгч, дэгдэмхий органик нэгдлүүдээс шаталтаар агаарт хүхрийн ислүүд, нүүрстөрөгчийн дан болон давхар ислүүд, метан болон метан агуулаагүй ууршимтгай органик нэгдлүүд болон азотын ислүүд ялгарна.

Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас жилд 0.33 тн PM_{10} тоосонцор, 0.31 тн $\text{PM}_{2.5}$ тоосонцор, 1.9 тн CO , 3.1 тн NO_x , 0.42 тн VOCs 0.0013 тн SO_2 тус тус үүсэж нисэх буудал орчмын агаар бохирдуулагчдын агууламжийг нэмэгдүүлж болзошгүй байна.

Хог хаягдал үүсгэх. Нисэх буудлын үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлын хадгалалт, тээвэрлэлт, түр хадгалах талбай зэрэг үе шатанд агаарт агаар бохирдуулагч бодисууд ялгарч болзошгүй. Тухайлбал, хог хаягдал задрах явцад дэгдэмхий органик нэгдлүүд (VOCs), метан (CH_4) зэрэг хий ялгарч, орчны агаарт тархах боломжтой. Мөн хог хаягдлыг шатаах замаар устгах тохиолдолд тоосонцор (PM), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), азотын ислүүд (NO_x), хүхрийн ислүүд (SO_2) зэрэг бохирдуулагч бодис агаарт тархах эрсдэл үүснэ. Иймд хог хаягдлыг хяналтгүй хадгалах, зохицуулалтгүй тээвэрлэх зэрэг нь орчны агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

3.2 ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС

- Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэн ус ашигласан тохиолдолд газрын доорх усны төвшин бууралт явагдах
- Нисэх буудлын ус хангамжийн эх үүсвэр нь Төв аймгийн төвийн бүсийн хүн амын ус хангамжийн эх үүсвэртэй зэрэгцээ байрлах тул газрын доорх усны төвшин буурснаар Төв аймгийн төвийн ус хангамжийн эх үүсвэрийн ажиллагаа доголдох
- Газрын доорх усны зөвшөөрөгдөх төвшин усны нөөц тогтоох хайгуул судалгааны ажлын үр дүнгээр 28.4 м гэж тогтоосон байна.

- Дулааны станцын яндангаас агаарт тархах олон тооны хортой бодисууд нь салхины үйл ажиллагаагаар агаарт дэгдэн, агаарын чийгтэй (бороо, цас) нэгдэн эргээд газрын гадаргуу дээр бууж гадаргын усыг бохирдуулах
- Бохир ус цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэрлэгдсэн бохир ус стандартын шаардлага хангахгүй тохиолдолд хөрс, гүний ус, гадаргын урсац буюу Зуунмодны голын ус бохирдох нөхцөл үүсэж болзошгүй
- 3 худгийн ашиглалтаас газрын доорх усанд нөлөөлөл үзүүлж байгаа эсэхийг хянаагүй тохиолдолд газрын доорх усны төвшин бууралт явагдах
- Хог хаягдал салхиар зөөгдөн гадаргын ус бохирдох

3.3 ХӨРСӨН БҮРХЭВЧ

2025 оны БОННУ нэмэлт тодотгол тайлангийн хүрээнд нисэх буудал дээр НУБИЭ ХХК барилга байгууламж барихгүй тул хөрсөн бүрхэвч эвдрэхгүй, харин хөрсний бохирдол үүсэж болох тул хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл бага байна. Харин нисэх буудал дээр авиа компани болон бусад ААНБ-ууд өөрсдийн эзэмшил талбайд шинээр барилга байгууламж барих тохиолдолд тухайн үед барилгын ажил хийх явцад бүтээн байгуулалт хийгдэх талбайн хөрсөн бүрхэвч эвдэрнэ. Төслийн үйл ажиллагааны үе шатанд ашиглалт, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаа орох бөгөөд төслийн үйл ажиллагааны үе шатанд үүсэх бохирдуулагч бодис, тос тосолгооны материал, хог хаягдал үүсэх хэмжээ маш бага байна. Гэсэн хэдий ч төслийн үйл ажиллагааны үе шатны дараах үйл ажиллагаануудын улмаас асгаралт, хорт аюулт химийн бодис, материалууд алдагдсан тохиолдолд хөрсний бохирдол үүсэж болзошгүй.

3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

Ургамлан нөмрөг.

- Нисэх буудлын хүрээнд эврэлд өртөж, хатуу хучилттай болсон 40.1 га талбай байна. Нисэх буудлын хүрээнд 3,869,730 м² (387 га) талбай буюу 38% -ийг хашаалж, үйл ажиллагаа явуулж байна.
- Аэрдормын талбайн хажуугийн зүлгийг шатааснаас ургамал нөмрөг устгах
- Шатах, тослох материал хадгалах, зөөвөрлөх үед асгах, машин, механизмаас тос тослох материал алдагдах, мөн осол аваарын үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж ургамалжилтад нөлөө үзүүлэх, бохирдуулах
- Бохир усны цэвэршүүлэлт стандарт шаардлагад нийцээгүй байгальд нийлүүлсэн тохиолдолд үед хөрс, ургамал, усан орчин бохирдох

Амьтны аймаг.

- Аэродромын орчимд агаарын хөлгийн өндөр алдах, газардах болон хөөрөх, өндөр авах үед хөхтөн амьтан болон шувууд онгоцтой мөргөлдөх, эндэх, агаарын хөлөгт аюул учруулахаас сэргийлж, шувуудыг үргээх, зайлуулах
- Жижиг мэрэгчдээр хооллодог махчин шувууд ихсэх, улмаар агаарын хөлөгтэй мөргөлдөх эрсдэл үүсэх

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

4.1 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

2025 онд батлагдсан БОННУ нэмэлт тодотгол тайланд БОМТ-г хэрэгжүүлэх 5 жилийн дундаж зардалд нийт 416.14 сая төгрөг, 2025 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд 62.908 сая төгрөг зарцуулахаар тооцоолсон байна.

Иймд НУБИЭ ХХК нь 2025 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт **62.908** сая төгрөг зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 4-1. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө			Нийт зардал (₮)
1.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө		9,700,000
		Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө		18,500,000
3.		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө		17,000,000
4.		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө		7,240,000
5.		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө		-
6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт	шинжилгээний хөтөлбөр	10,468,000
Нийт				62,908,000

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1.	Агаар бохирдуулагч бодисууд ялгарах	Бохирдуулагч хийн ялгаралтад хяналт тавьж шаардлагатай тохиолдолд бууруулах арга хэмжээ авах. Дулааны станцын яндангийн дагуу агаарын чанарын шинжилгээ хийлгэх	Агаар бохирдуулагч эх үүсвэр бүр	удаа	1	ҮАЗ*		Жил бүр	Агаарын тухай хуулийн 9.1.3, 9.1.4-р зүйл MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 6456:2014. Нүүрсний ангилал
2.		Утааны яндангийн уутат шүүлтүүрийн хэвийн, үйл ажиллагааг хангаж ажиллах, тогтоосон хугацаанд солих	Дулааны станц	удаа		ҮАЗ*		Жил бүр	
3.		Итгэмжлэгдсэн лабораториор нүүрсний шинжилгээ хийлгүүлэх, нүүрсний чанарын горимд хяналт тавих. Нүүрс дулааны станцын стандартад нийцэхгүй тохиолдолд нүүрсийг солих арга хэмжээ авах	Дулааны станц	удаа	1	1,500,000		Халаалтын улирлын саруудад	хөдөлгүүртэй автомашин – утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009. Дизель хөдөлгүүртэй автомашин – утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
4.		Хөргөлтийн системийн R22 хөргөх бодисыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, байгаль орчинд ээлтэй хөргөх бодисоор шинэчлэх	Зорчигч үйлчилгээний барилгын хүзүүвч			ҮАЗ*		6-8 сарын хооронд	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5.		Хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол хийж, хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Нисэх буудал	ш	1	ҮАЗ*		БОННУ тайлангийн хүрээнд 1 удаа (2-5 дахь жилүүдэд)	
6.		Хөндлөнгийн итгэмжлэгдсэн байгууллагаар агаарын чанарын хяналт шинжилгээ хийлгэж байх	Нисэх буудал	удаа	4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.		Улиралд- 1 удаа	
7.		Нисэх буудлын эргэн тойронд мод, бут сөөг тарьж тоосжилт, дуу чимээг бууруулах	Нисэх буудал	Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав.				5-9-р сарын хугацаанд	
8.	Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас агаар бохирдуулагч бодисууд ялгарах	Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрийн яндангаас орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс тээврийн хэрэгслүүдийг техникийн хяналтын үзлэгт жил бүр хуваарийн дагуу хамруулж байх	Өөрийн эзэмшлийн бүх тээврийн хэрэгслүүд	ш	126	ҮАЗ*		Жил бүр	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам (2021.12.31, Дугаар А/199) MNS5013:2009. Бензин хөдөлгүүртэй автомашин – утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS5014:2009. Дизель хөдөлгүүртэй автомашин – утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
9.		Ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгсэл ашиглахгүй байх	Бүх газарт ашиглагдах тээврийн хэрэгсэл	ш	126	-		Ашиглалтаас гарах тухай бүрт	
10	Агаарын хөлөг	Агаарын хөлөг болон тээврийн хэрэгслүүдэд хэрэглэх шатахууны чанарыг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж байх	Нисэх буудалд нийлүүлэгдэж байгаа бүх түлш	N/A	N/A	ДҮА*		Түлш худалдан авах тухай бүрт	

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал								1,500,000	
Дуу чимээ, чичиргээ									
11	Онгоц хөөрч буух, явгалах үе болон тээврийн хэрэгсэл, дуу дохио зэргээс дуу чимээ үүсэх	Сонсголыг хамгаалах нийлэг бөглөө 10-20 дБ, чихэвч 20-40 дБ нь дуу шуугианыг багасгаж чаддаг тул хамгаалах хэрэгслийг агаарын хэсгийн ажилчдад шуугиан ихтэй газарт ашиглах замаар ажиллагсдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх. Ажилчдыг сонсгол хамгаалах хэрэгслээр хангаж, тогтмол хэрэглэж хэвшүүлэх	Нисэх буудлын ажилчид	ш	2 болон 4 дэх жилд		Ажлын цагаар	MNS 6768:2019. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугиан	
12		Дуу чимээний тархалтын зураглал хийх, дуу чимээний менежментийн төлөвлөгөө боловсруулах	Нисэх буудал	удаа	1	3 болон 5 дахь жилд			
13		Онгоцны замын эргэн тойронд бут сөөг бүхий ногоон зурвас байгуулах	Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав.						5-9 сарын хугацаанд
Дуу чимээ, чичиргээний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал								-	
Хөрсөн бүрхэвч									
14	Барилгын үйл ажиллагааны	Төлөвлөлтийн дагуу цаашид барилга байгууламж баригдахгүй болон үйл ажиллагаанд өртөөгүй талбайг доройтуулахгүйгээр хамгаалах. Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдолт үүсэхээс урьдчилан сэргийлэх, тогтмол хяналт тавих	Нисэх буудал	удаа	N/A	N/A	ҮАЗ*	Жил бүр	MNS 5917:2018. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага Хөрс хамгаалах тухай хууль MNS 5918:2023. Эвдэрсэн газрыг ургамалжуулах.

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
15	үед хөрсөн бүрхэвч эвдрэх	Нисэх буудлын орчинд төрийн болон бусад байгууллагууд шинээр барилга байгууламж баригдах тохиолдолд (НУБИЭ ХХК барилга барихгүй) хуулсан газрын шимт хөрсийг дахин ашиглах, барилгажилт дууссаны дараа техникийн нөхөн сэргээлт хийх, зүлэгжүүлэх ажилд хяналт, шаардлага тавих	Нисэх буудал	удаа	N/A	N/A	ҮАЗ*	Жил бүр	Техникийн шаардлага ерөнхий
16		Нисэх буудлын бүтээн байгуулалтын үед эвдэгдэж, орхигдсон талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Нисэх буудлын эвдэгдэж, орхигдсон талбай	га	40	N/A	ҮАЗ*	2 дахь жил	
17	Шатах тослох материал болон хог хаягдлаар хөрсөн бүрхэвч бохирдох	Нийтийн эзэмшлийн зогсоолд шатах тослох материал асгарсан тохиолдолд шингээж авах тусгай талбай гаргах	Авто машины зогсоол	удаа	1	-	ҮАЗ*	Энэхүү үнэлгээний хүрээнд 1 удаа (2 дахь жилд)	
18		Захиргааны барилгын хажуу талын ажилчдын автомашины зогсоолыг хатуу хучилттай болгох (төвлөрсөн хогийн цэг хамт байрлана)	0.75 км зам	удаа	1	N/A	ХӨЗ*	Энэхүү үнэлгээний хүрээнд 1 удаа	
19		Асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах, асгаралтын иж бүрдлийг зогсоолын бүсэд асгаралт гарч болзошгүй газруудад байрлуулах	Авто машины зогсоол	ш	3	1,000,000		Жил бүр	
Хөрсөн бүрхэвч сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал								1,000,000	
Усан орчин									

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
20	Газрын доорх усны хэрэглээг хүрэлцэхгүй байх	Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх	3 худаг	удаа	1	-		Энэхүү үнэлгээний хүрээнд 1 удаа	Усны тухай хуулийн 28, 29-р зүйл
21		Жил бүр ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж, Туул голын сав Газрын захиргаатай гэрээ байгуулж, гэрээг дүгнүүлж байх	-	Удаа	1	-		Жил бүр	
22		Ус ашигласны болон бохирдуулсны төлбөр төлөх	3 худаг	Удаа	1	6,000,000		Жил бүр ашигласан хэмжээгээр	Усны тухай хуулийн 25.1, 30.1.5-р зүйл
23	Ундны ус бохирдох	Худгийн усан санг тогтсон хуваарийн дагуу угааж цэвэрлэх	Ус цэвэршүүлэх байгууламж, Бохир ус цэвэрлэх байгууламж	удаа	4	-		-Хэвийн ажиллагааны үед улиралд 1 удаа -Усан санд лаг, хог, шавар хуримтлагдсан бол илэрсэн тухай бүрт - Усанд өнгө, үнэр, амт өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй -Үер, усны нэвчилт болсон бол тухай бүрт	
24		Ус хангамж, цэвэрлэх байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээг тогтмол хийлгэх	Ус цэвэршүүлэх байгууламж, Бохир ус			ДҮА*		Тогтоосон хугацаанд	

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
			цэвэрлэх байгууламж						
25		Худгийн ойр орчмын талбайг цэвэрлэх, бүртгэл хөтлөх	Худгаас 1-3 м хүртлэх талбай	удаа	52	ДҮА*		7 хоног бүр	
26	Худгийн автомат камерт эвдрэл гэмтэл гарснаар худгийн хэвийн үйл ажиллагааг хянах болмжгүй болох	Худгийн автомат камерийн хяналтын хэвийн ажиллагааг тогтмол шалгаж, хэвийн ажиллагааг хангуулах, засвар үйлчилгээг тухай бүрт хийлгэх болох	3 худаг	Удаа	12	ДҮА*		Сард 1 удаа	Ус хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ, барилга байгууламж, БНБД 40-04-16
27		Усны хяналт мониторингийг тогтмол хийх	3 худаг						
28	Гүний хэрэглээ усны	Зорчигч терминалын барилгын дээврийн усыг хуримтлуулах шугам сүлжээг шийдэж, мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч, хур борооны усыг хуримтлуулж, дахин ашиглах	Зорчигч терминалын барилга	м²	15,000 орчим	ҮАЗ*		Төслийн хугацаанд	
Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал								6,000,000	
Амьтны аймаг									
29	Агаарын хөлөг	Радар систем судлах, боломжтой бол суурилуулах	Нисэх зурвасын ойр орчим	-	-	ДҮА*		БОННУ тайлангийн хүрээнд 1 удаа	-
30	Шувуутай мөргөлдөх	Нисэх буудлын шувуу, хөхтөн амьтдын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх	15 км	1 удаа	2 жилд	ДҮА*		2 жил тутам	-

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
31		Шувууд үүрлэхээс сэргийлж байгууламжуудад тор суурилуулах	Шувуу үүрлэдэг газруудад	удаа	1	ДҮА*		Үйл ажиллагааны турш	-
32		Шувуудыг үргэх ultrasonic төрлийн төхөөрөмж суурилуулж, хянах	Онгоц хөөрөх, буух зурваст	ш	3	ДҮА*		2-5 дахь жилүүдэд	-
Амьтны аймгийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал								-	
Ургамлан нөмрөг									
33	Аэрдормын талбайг шатааснаас ургамал нөмрөг устгах	Ургамлыг жил бүр шатаахгүй байх /багадаа 5 жилд нэг шатааж бусад жил хадах/	Аэродромын талбай	га	40.0	2-5 дахь жилүүдэд			
34		Ургамлын үр цуглуулах, хадгалах журам боловсруулж, ургамал хадахын өмнө ургамлын үр цуглуулах		га	N/A	1,000,000			
35	Зүлэгжүүлсэн талбай талхлагдах	Зорчигч терминалын барилгын хойд талын зүлэгжүүлсэн талбайн ургамлын бүрхэвчид аль болох сөрөг нөлөөлөл үзүүлэхээс сэргийлэх үүднээс тухайн талбай дээр ажилчид болон машин, техник явуулахыг хориглож тэмдэгжүүлэх	Зүлэгжүүлсэн талбайнууд	ш	10	200,000		Эхний жилүүдэд	
Ургамлан нөмрөгийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал								1,200,000	
НИЙТ ЗАРДАЛ, ₮								9,700,000	

Тайлбар: ҮАЗ*- Үйл ажиллагааны зардал
ДҮА*-Дотоод үйл ажиллагаагаар
ХОЗ*-Хөрөнгө оруулалтын зардал

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Газрын тухай хуулийн 56.6-р зүйл, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйлд заасны дагуу газар эзэмшигч нь эзэмшлийн талбайн 10 хувиас багагүй талбайд ногоон байгууламж байгуулахаар заасан байдаг.

НУБИЭ ХХК нь 2023 онд Бат–Өндөр Хайрхан ХХК-аар Нисэх буудлын Зорчигч үйлчилгээний барилгын гадна авто машины зогсоол орчмын нийт 32,000 м2 талбайд зүлэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгүүлсэн байна. Нисэх буудал ашиглалтад орохоос өмнө 2017-2018 онд нисэх зурвасын талбайн 75 га талбайг зүлэгжүүлсэн байна.

2025-2029 оны БОННУ-ний хүрээнд нисэх буудлын талбайд шинээр зүлэгжүүлэлтийн ажил төлөвлөхгүйгээр 500 ш мод тарихаар төлөвлөсөн. Мөн өмнө хийгдсэн ногоон байгууламжийн арчлалт тордолгоог хариуцан хийхийг зөвлөсөн. Үүнтэй холбоотойгоор нисэх буудлын ногоон байгууламжийн усалгааг гэрээт байгууллагаар хийлгэхэд зардал өндөр гардаг тул усалгааны системийг суурилуулахаар тооцоолсон.

Хүснэгт 6-1. Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал (1 жил), ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.		Зүлэгжүүлэлт, тарьсан модны арчилгаа	2000 ш мод, зүлэгжүүлсэн талбай			-	-	-	
2.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа тордолгоог хийх	Мод тарих	-	500	ш	15,000	7,500,000	5-9 сар	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
3.		Мод тарих бусад зардал				6,000,000			
4.		Усалгааны систем суурилуулах			2 дахь жилд				
5.		Санамж байрлуулах				5,000,000			
НИЙТ ЗАРДАЛ, ₮								18,500,000	

БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7-1. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй аюул, осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Байгалийн гамшигт үзэгдэл	Тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэлийг тодорхойлох, түүнийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх зорилгоор гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, ажилчдад тогтмол сургалт зохион байгуулах	Нэгж төлөвлөгөө	1	5,000,000		Гамшгийн эрсдэлийн үнэлгээг 3 жилд 1 удаа хийлгэх ба үйл ажиллагааны турш даган мөрдөнө.	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль -Гамшгаас хамгаалах тухай хууль
2.		Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагаар сургалт зохион байгуулуулж, ажилчдыг дадлагажуулах	Нэгж сургалт	1	500,000		Жилд 1 удаа	
3.		ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж нислэгийн үйл ажиллагаанд харгалзан үзэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, дохиог дамжуулан анхааруулга өгч байх	-	-	-		Үйл ажллагааны турш	
4.		Үерийн аюулаас сэргийлэхийн тулд ус зайлуулах үерийн усны суваг шуудууны үзлэг шалгалтуудыг тогтмол явуулж байх, цэвэрлэх	-	-	ДҮА*		Үйл ажиллагааны турш	
5.	Гал түймэр	Гал унтраах багаж, тээврийн хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалтыг хуваарийн дагуу хийх, хэвийн үйл ажиллагааг хангуулах	ш	Бүх байгууламж	10,000,000		Үйл ажиллагааны турш	MNS5566:2020. Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

№	Гол болон болзошгүй аюул, осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
6.		Галын аюулын анхааруулга самбарыг ил байршуулах			1,000,000			унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS4244:1994. Хөдөлмөр хамгааллын систем
7.		НУБИЭ ХХК-ийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлуулж, дагаж мөрдөх	Нэгж сургалт	1	500,000		Жилд 1 удаа	Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS0639:2016. Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж болон тээврийн хэрэгслийн нэр томъёо ба тодорхойлолт
8.	Үйл ажиллагааны үеийн осол гэмтэл	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Иж бүрдэл	-		ҮАЗ*	Үйл ажиллагааны турш	MNS ISO13688:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага
9.		Бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, сургалт зохион байгуулах	Нэгж сургалт	-	-	ҮАЗ*	Үйл ажиллагааны турш	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
НИЙТ ЗАРДАЛ, ₮								17,000,000

БҮЛЭГ 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8-1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1.	Энгийн	Хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгаа хийж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг авах	Төслийн талбай	ш	1	-	-	5 жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйл
2.		Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	Төслийн талбай	ш	1	-	5,000,000	Эхний жил	Хог хаягдлын тухай хуулийн 4-р бүлэг
3.		Хог хаягдлын үйл ажиллагааны дотоод журам боловсруулж, ажилчдад сургалт зохион байгуулах	Төслийн талбай	удаа	1-2	-	ҮАЗ	Жилд 1-2 удаа	
4.		Бусад хог хаягдлыг гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Төслийн талбай	удаа	60	-	240,000	Сард 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.4-р зүйл, 4-р бүлэг
5.		Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх	Төслийн талбай	удаа	10	-	1,000,000	Жилд 2 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.10-р зүйл

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
6.		Батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд сумын Засаг даргад хүргүүлэх	НУБИЭ ХХК	Нэгж тайлан	1	-	ҮАЗ	Жил бүрийн 12.15-с өмнө тайлан мэдээг гарган хүргүүлэх	Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг
7.		Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эх үүсвэр дээр түр хадгалах цэгийн нөхцөл байдлыг сайжруулах	Төслийн талбай	ш	1	-	ҮАЗ	Жилд 2 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 28 дугаар зүйл
8.	Аюултай	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, хадгалах шилжүүлэх үйл ажиллагаанд байнгын хяналтыг тавьж, бүртгэл хөтлөх	НУБИЭ ХХК	-	-	-	ҮАЗ	Сард 1 удаа	
9.		Хэвийн үйл ажиллагааны үед аюултай хог хаягдалтай харьцах болон аюул ослын үед ажиллах зааварчилгааг түүнтэй харьцдаг ажилтан бүрд сургаж, дадлагажуулах	Аюултай хог хаягдалтай харьцах ажилчид	Нэгж сургалт	-	-	1,000,000	Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг
10		Аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэх, устгуулах	Төслийн талбай	кг	-	-	ҮАЗ	Жилд 4 удаа	
НИЙТ ЗАРДАЛ, ₮						7,240,000			

БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 9-1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
Агаарын чанар							
1.	Агаарын чанарын үзүүлэлт: - Азотын давхар исэл, хүхэрлэг хий, нүүрстөрөгчийн дутуу исэл, озон, нийт тоосонцор, PM2.5, PM10 Шуугиан	Нисэх зурвасын баруун төгсгөл орчим агаарын хөлөг хөөрөх үед					
		Нисэх зурвасын баруун төгсгөл орчим агаарын хөлөг буух үед					
		Нисэх зурвасын зүүн төгсгөл орчим агаарын хөлөг хөөрөх үед					
		Нисэх зурвасын зүүн төгсгөл орчим агаарын хөлөг буух үед					
		Нисэх зурвасын төгсгөл орчим агаарын хөлөггүй энгийн үед	Жилд 1 удаа	-	4,140,000	-MNS 4585:2016 Агаарын чанар.Техникийн шаардлага, -MNS 3384:1982 Сорьц авахад тавих шаардлага,	
		Перрон талбай орчим (агаарын хөлгийн хөдөлгүүр асаалттай байх үед)					
		Нисэх буудлын автомашины зогсоол					
	Дулааны станцын бамбар утааны дагуу 100 м						
	Дулааны станцын бамбар утааны дагуу 1 км						

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
		Зорчигч үйлчилгээний терминалын орчимд 1 цэг					
		Аюулгүйн зурваст агаарын хөлөг буух үед					
		Агаарын хөлөг хөөрч буугаагүй үед аюулгүйн зурваст					
		Нисэх буудлын автомашины зогсоол					
		Нисэх буудлаас 1000 метр хүртлэх зайнд					
		Нисэх буудлаас 3000 метр хүртлэх зайнд					
2.	Усан орчин	- Ерөнхий хими физикийн шинжилгээ - Урвалын орчин (pH) Хүнд металлын шинжилгээ	3 худаг	Улиралд 1 удаа	-	648,000	- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ - MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
		pH, БХХ, ХХХ, NH4, Ж/б, NOx					

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 он

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
3.	Хөрс	• Ялзмаг • Урвалын орчин (рН) • Карбонат, нитрат, фосфор, кали • Давсжилт • Механик бүрэлдэхүүн • Эзлэхүүн, жин • Хүнд металлууд Элэгдэл, эвдрэл				360,000	• MNS 2305:1994. Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам • MNS 3310:1991. Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга • MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4.	Ургамлын судалгаа	Мэргэжлийн байгууллагаар		Жилд 1 удаа	5,000,000		Батлагдсан арга зүйн дагуу
5.	Шувуу, хөхтөн амьтны судалгаа	Мэргэжлийн байгууллагаар		2 жилд 1 удаа	ҮАЗ*		Батлагдсан арга зүйн дагуу
НИЙТ ЗАРДАЛ, ₮							10,468,000

Тайлбар: ҮАЗ*- Үйл ажиллагааны зардалд тусгах

БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10-1. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
1.	Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 9.9-д заасны дагуу тухайн жилийн БОМТ батлуулахдаа харьяа сумын тусгай дансанд байгаль орчныг хамгаалах үүргийн баталгаа болох тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын зардлын 50-иас доошгүй хувийг байршуулах	ҮАЗ*		
2.	“Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл”-ийг шинэчилж авах	-	Эхний жил	Хариуцсан мэргэжилтэн
3.	Химийн бодисын агуулахууд дээр дүгнэлт гаргуулах	-	Эхний жил	Хариуцсан мэргэжилтэн
4.	Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	-	2 жил тутамд нэг удаа	БО мэргэжилтэн
5.	Байгаль орчны гүйцэтгэлээ сайжруулах зорилгоор Байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх /MNS:ISO 14001:2016/	ДҮА*		
6.	Хог хаягдлын тухай хуулийн 23.4-т заасны дагуу аюултай хог хаягдлыг нэр төрөл, хуримтлагдсан хэмжээгээр нь бүртгэл хөтөлж байх	ДҮА*	Сар бүр	Хариуцсан мэргэжилтэн
7.	Газар эзэмших гэрээг дүгнүүлэх	ҮАЗ*	Жил бүр	Хариуцсан мэргэжилтэн
8.	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр орон нутагтай хамтран ажиллах	ҮАЗ*	Тухай бүрд	Удирдлага, БО мэргэжилтэн
9.	Аюултай хог хаягдал үүсгэгч болон аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь хог хаягдлын тухай хуулийн 8.1.9.а-д заасны дагуу бүртгүүлж, бүртгэлийн дугаар авах	-	Эхний жил	Удирдлага, БО мэргэжилтэн
10.	Нисэх буудлын талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэх	-	5 жилд нэг удаа	Удирдлага, БО мэргэжилтэн
Нийт			-	

Тайлбар: ҮАЗ* - Үйл ажиллагааны зардал

БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. БОМТ-г боловсруулж, БОАЖЯ-нд батлуулахаар хүргүүлж, батлагдсаны дараа тухайн жилийн БОМТ-г ханган биелүүлж, түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ний дотор Төв аймгийн БОГ-т хүргүүлнэ.

Хүснэгт 11-1. Тайлагнах хуваарь

БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцан зохион байгуулах
<i>Төв аймгийн Байгаль орчны газар</i>	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг танилцуулж, дүгнүүлнэ	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг тусгасан байна. Тухайн ажлын гүйцэтгэл, үр дүнтэй	Жил бүрийн 11 дүгээр сарын 01- ээс өмнө	Удирдлага болон Байгаль орчны мэргэжилтэн
<i>БОУАӨЯ</i>	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг цахим хэлбэрээр хүргүүлэх	холбоотой фото зураг болон шинжилгээний хариугаар баталгаажсан байна.	11 дүгээр сарын 01- ээс өмнө	Хариуцах албан тушаалтан

ДҮГНЭЛТ

“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын 2025 оны БОМТ-ний хүрээнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 9,700,000₮, орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд 18,500,000₮, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 17,000,000 ₮, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд 7,240,000₮, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 10,468,000₮ буюу нийт 62,908,000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөө.